

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас:7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ч.Сугардорж Утас: 7036-2442 Цахим хаяг: sugardorjch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХУШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЗАХИРАХБААТАР ТАНАА**

2026-03-25 № 19А-2026/003/НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.12.2, 2.12.3, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус

зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- “Хушаат Дуут хад” ААТҮГ нь тайланд онд 29,500.0 мянган төгрөгийн анхан шатны дэмжих баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас хөрөнгө оруулалтын шинж чанартай буюу 16,000.0 төгрөгийн Nissan x-trail T31 маркийн суудлын автомашин худалдан авсан,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3 төсөл, арга хэмжээний гэрээнд тусгагдсан 5 хувийн чанарын баталгаа буюу 11,366.7 мянган төгрөгийг суутган тооцолгүй, гүйцэтгэгчид шилжүүлсэн,
- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 1,513.1 мянган төгрөгөөр тасалсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант төсвийн хөрөнгөөр багийн дарга нарт 16,000.0 мянган төгрөгийн суудлын автомашин, сумын ИТХ-ын төлөөлөгчдөд 19,829.5 мянган төгрөгийн 21 ширхэг таблет худалдан авч, ОБЕГ-аас 179,000 мянган төгрөгийн Toyota Hilux автомашин, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 100,000.0 мянган төгрөгийн ахмадын рашаан, сувиллын барилга, 49,890.0 мянган төгрөгийн мал эмнэлгийн ариутгалын автомашин, аймгийн хөрөнгө оруулалтаар 9,872.7 мянган төгрөгийн киоск машин зэргийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,681,865.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,787,928.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 696,740.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 197,195.5 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,205,647.3 мянган төгрөг буюу 82.2 хувьтай байгаа нь урсгал зардлыг 186,015.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 93,007.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Баянгол сумын Засаг дарга нь тайлант онд 6 зорилт, 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	789,658.55	809,916.07
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	480,297.19	459,956.5
3	АВЛАГА	124,825.97	93,307.15
4	УРЬДЧИЛГАА	14,838.61	23,686.54
5	БАРАА МАТЕРИАЛ	169,696.78	232,965.88
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,760,796.22	2,262,324.72
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,760,796.22	2,262,324.72
8	Биет хөрөнгө	1,638,545.42	2,140,073.92
9	Биет бус хөрөнгө	122,250.8	122,250.8
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,550,454.76	3,072,240.78
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,708.46	36,493.3
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,708.46	36,493.3
13	Өглөг	6,708.46	36,493.3
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,543,746.3	3,035,747.49
15	Засгийн газрын хувь оролцоо	2,543,746.3	3,035,747.49
16	Засгийн газрын оруулсан капитал	310,470.44	310,470.44
17	Хуримтлагдсан үр дүн	2,072,720.09	2,564,721.28
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,555.77	160,555.77
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,550,454.76	3,072,240.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,019,429.91	2,893,896.62
2	ТАТВАРЫН ОРЛОГО	753,416.74	726,050.47
3	Орлогын албан татвар	404,092.53	375,754.16
4	Хувь хүний орлогын албан татвар	431,028.46	412,817.22
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-26,935.93	-37,063.06
6	Хөрөнгийн албан татвар	229,559.54	188,642.95
7	Бусад татвар, төлбөр, хураамж	119,764.67	161,653.36
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	712,820.29	2,167,846.15

9	Тусламжийн орлого	0.0	966,996.85
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,553,192.87	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,780,219.65	1,933,849.86
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,619,576.21	1,798,161.86
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,573,761.03	1,798,061.86
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	662,314.08	903,079.85
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,447.49	110,444.3
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,754.8	345,038.39
17	Хангамж, бараа материалын зардал	54,431.94	53,669.16
18	Эд хогшил, урсгал засварын зардал	90,288.05	58,895.15
19	Томилолт, зочны зардал	7,566	8,768.2
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,415.31	132,150.51
21	Бараа үйлчилгээний бусад зардал	158,543.37	186,016.29
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,815.18	100
23	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	160,643.44	135,688.01
24	АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,239,210.26	960,046.75
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	481,015.12	468,045.56
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-481,015.12	-468,045.56
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	758,195.14	492,001.19

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,785,551.16	1,785,551.16
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,785,551.16	1,785,551.16
3	Тайлант үеийн үр дүн	758,195.14	758,195.14
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,543,746.3	2,543,746.3
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,543,746.3	2,543,746.3
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,543,746.3	2,543,746.3
7	Тайлант үеийн үр дүн	492,001.19	492,001.19
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,035,747.49	3,035,747.49

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,481,267.65	2,263,009.47
2	ТАТВАРЫН ОРЛОГО	753,416.74	726,050.47
3	Орлогын албан татвар	404,092.53	375,754.16
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-26,935.93	-37,063.06
5	Хөрөнгийн албан татвар	229,559.54	188,642.95
6	Бусад татвар, төлбөр, хураамж	119,764.67	161,653.36
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,912.71	10,163.6
8	Газрын төлбөр	91,299.06	134,567.45
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,552.9	16,922.31
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,028.03	1,536,959
11	Нийтлэг татварын бус орлого	168,028.03	140,720.62
12	Тусламжийн орлого	0.0	956,905.48
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	439,332.9
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,559,822.88	0.0
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,491,181.05	1,659,787.09
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,491,181.05	1,659,787.09
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,445,365.87	1,659,687.09
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	662,314.08	903,079.85
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,447.49	110,523.78
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	390,193.45	345,322.39
21	Хангамж, бараа материалын зардал	64,329.39	81,345.6
22	Эд хогшил, урсгал засварын зардал	90,288.05	62,086.15
23	Томилолт, зочны зардал	7,566	8,768.2
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,369.4	128,948.1
25	Бараа үйлчилгээний бусад зардал	14,858.01	19,613.02
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,815.18	100
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	990,086.6	603,222.38
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	690,116.56	623,563.07
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	690,116.56	623,563.07

30	Дотоод эх үүсвэрээр	690,116.56	623,563.07
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-690,116.56	-623,563.07
32	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	14,838.61	0.0
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-14,838.61	0.0
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	285,131.43	-20,340.69
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	195,165.76	480,297.19
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	480,297.19	459,956.5

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,231,319.30	2,195,502.12	(35,817.18)	98.39
11	Татварын орлого	732,174.50	726,050.47	(6,124.03)	99.16
110	Орлогын албан татвар	409,087.00	375,754.16	(33,332.84)	91.85
1100	Хувь хүний орлогын албан татвар	430,571.90	412,817.22	(17,754.68)	95.88
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(21,484.90)	(37,063.06)	(15,578.16)	172.51
113	Хөрөнгийн албан татвар	167,646.20	188,642.95	20,996.75	112.52
118	Бусад татвар, төлбөр, хураамж	155,441.30	161,653.36	6,212.06	104.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	38,807.00	10,163.60	(28,643.40)	26.19
1181	Газрын төлбөр	93,239.00	134,567.45	41,328.45	144.33
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	23,395.30	16,922.31	(6,472.99)	72.33
12	Татварын бус орлого	1,499,144.80	1,469,451.65	(29,693.15)	98.02
120	Нийтлэг татварын бус орлого	130,822.40	101,129.25	(29,693.15)	77.30
120003	Торгуулийн орлого	5,300.00	29,239.97	23,939.97	551.70
122	Тусламжийн орлого	928,989.50	928,989.50	0.00	100.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв	439,332.90	439,332.90	0.00	100.00

	хоорондын шилжүүлэг				
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	534,855.30	2,114,385.67	1,579,530.37	395.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	(359,080.90)	1,510,652.09	1,869,732.99	(420.70)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,786,428.80	1,601,813.73	(184,615.07)	89.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	975,460.30	902,740.28	(72,720.02)	92.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,593.00	110,480.90	(19,112.10)	85.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	353,527.50	344,598.39	(8,929.11)	97.47
2104	Хангамж, бараа материалын зардал	52,904.30	40,825.51	(12,078.79)	77.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,922.10	81,915.65	(2,006.45)	97.61
2107	Томилолт, зочны зардал	9,916.00	8,768.20	(1,147.80)	88.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,822.60	103,157.28	(59,665.32)	63.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,283.00	9,327.52	(8,955.48)	51.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	(2,145,509.70)	(91,161.64)	2,054,348.07	4.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	(2,147,009.70)	(91,261.64)	2,055,748.07	4.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500.00	100.00	(1,400.00)	6.67
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	696,740.70	603,733.57	(93,007.13)	86.65
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	197,195.50	0.00	(197,195.50)	0.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,696,464.00	81,116.46	(1,615,347.54)	4.78
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,696,464.00)	(81,116.46)	1,615,347.54	4.78
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,696,464.00)	(81,116.46)	1,615,347.54	4.78

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	480,165.59	480,165.59	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	459,485.17	459,485.17	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	5. Тайлант он-нийт устгалын дараах
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	57,535.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,535.9
122	Тусламжийн орлого	57,535.9
1221	Хандив тусламж /дотоод/	57,535.9
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,535.9

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **10,535.2** мянган төгрөгийн залруулаагүй алдаанд¹ зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулаагүй алдаа:

- Орон нутгийн ерөнхий орлогын дансны авлага, өглөгийг 10,535.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга*”-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...*”, санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн ерөнхий орлогын дансны авлага, өглөгийг илүү тайлагнасан алдааг 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулах, ажил гүйлгээг холбогдох стандарт, заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Аудитаар нийт **79,505.7** мянган төгрөгийн алдаа илэрснээс 58,379.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 21,125.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **58,379.9** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 39,041.4 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас хөрөнгө оруулалтын шинж чанартай буюу 16,000.0 мянган төгрөгийн Nissan x-trail Т31 маркийн суудлын автомашин худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “*төсвийн хөрөнгө оруулалт*” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээнд зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээний гэрээнд тусгагдсан 5 хувийн чанарын баталгаа буюу 11,366.7 мянган төгрөгийг суутган тооцолгүй, гүйцэтгэгчид шилжүүлсэн.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д “*Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно*”, ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн 4.17-д “*Төсвийн хүндрэлээс шалтгаалан санхүүжилт тасрах, удааширсан тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр гэрээт ажлыг хугацаанд нь дуусгаж хүлээлгэн өгөх санхүүгийн чадвартай байна. Чанарын баталгаа 5 хувь*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийн оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний чанарын баталгааг гэрээнд заасны дагуу барьцааны дансанд байршуулж, баталгааны хугацаа дуусахад буцаан олгож байх албан шаардлага хүргүүлэв.

3. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 1,513.1 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “*Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, бүрэн төвлөрүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. “Хушаат Дуут хад” ААТҮГ -ын тайланд онд хийгдсэн дараах ажил гүйлгээ нь анхан шатны дэмжих баримтуудаар нотлогдохгүй байна. Үүнд:

- Бумбат тохойн малчдын хадлан тэжээл бэлтгэх зам засварын ажил- 20,000.0 мянган төгрөг,
- Төвлөрсөн хогийн цэгийг тархалтыг хумих ажил- 3,500 мянган төгрөг,
- Өвсний тэжээлийн нөөц бүрдүүлэх ажил- 6,000.0 мянган төгрөг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.5 дахь “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны дэмжих баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж, үнэн зөв, бодиттой тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхтэй холбоотой

Илрүүлэлт: Засгийн газрын нөөц хөрөнгөөс ой хээрийн түймэрт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас үзэсгэлэн худалдаанд зориулж олгосон санхүүжилтийн зарцуулах эрхийг хөтөлбөр, зориулалтын дагуу нээлгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.12.2-д "Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр харьяалагдах төрийн санд хүргүүлнэ: 2.12.2.2.нэмэлт төсвийг зарцуулах тухай төсвийн захирагчийн шийдвэр болон бусад холбогдох шийдвэр", 2.12.3-д "Төрийн сан нь энэ журмын 2.12.2-т заасан шаардлагыг хангасан төсвийн байгууллагын хүсэлтийг хянаж, ажлын 3 өдрийн дотор зарцуулах эрхийг олгоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийг зарцуулахдаа тухайн төсвийн захирагчийн шийдвэрт тусгагдсан хөтөлбөр, зориулалтын дагуу зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг харьяа төрийн санд хүргүүлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНЕО-ын авлага, өглөгийг илүү тайлагнасан.	1	10,535.2			1	10,535.2			1	10,535.2	1	10,535.2
Дүн	1	10,535.2			1	10,535.2			1	10,535.2	1	10,535.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	28,879.9			3	28,879.9						
ЗДТГ	1	21,125.8					1	21,125.8				
“Хушаат Дуут хад” ААТҮГ	1	29,500.0			1	29,500.0						
Сумын ТТЗ-ийн дүн	5	79,505.7			4	58,379.9	1	21,125.8				

